



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2022.11.10 № НВ

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр"
ТӨХК-ийн талаар асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараахь асуулгыг тавьж байна.

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК нь анх 1990 оны 04 сарын 14-ний өдрийн Сайд нарын Зөвлөлийн 160 дугаар тогтоолоор Монгол болон Япон улсын засгийн газар хоорондын гэрээний дагуу Дархан-Сэлэнгийн бүс нутаг дахь Баянгол, Төмөртэй, Төмөртолгой гэх 3 төмрийн хүдрийн орд газруудыг түшиглэн байгуулагджээ. Үйлдвэрийн шавыг 1990 оны 7 сарын 4-ний өдөр тавьснаар бүтээн байгуулалтын ажил 4 жилийн хугацаанд явагдаж, 1994 оны 7 сарын 4-ний өдөр бүрэн хэмжээгээр ашиглалтад орсон түүхтэй. 1994 онд үйлдвэр ашиглалтанд орсноос хойш компанийн үйл ажиллагаа өргөжин тэлсээр Уул уурхайн олборлолт, боловсруулалт, Төмөрлөгийн үйлдвэрлэл, гадаад болон дотоод худалдаа гэсэн үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж байна.

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК нь Монгол Улсдаа анхны бөгөөд хамгийн том ган үйлдвэрлэгч, хар төмөрлөгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй үндэсний томоохон компани ба төмрийн хүдрийн олборлолт, боловсруулалт, экспорт, гангийн үйлдвэрлэл гэсэн чиглэлээр өнөөдрийн байдлаар нийт 1400 гаруй ажиллагсадтайгаар үндсэн үйл ажиллагаагаа явуулж, төрөл бүрийн хэмжээтэй барилгын иржгэр, гөлгөр ган туйван, ган булан, ган бөмбөлөг болон төмрийн хүдрийн баяжмал гэсэн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж, дотоод болон гадаадын зах зээлд борлуулсан ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК "Монгол Ган цогцолбор I" төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа ба тус төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд жилд 350 мянган тонн ган цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай, аргалж, хорголж, коксын үйлдвэрүүд, бусад дэд бүтцийг багтаасан, ган үйлдвэрлэх иж бүрэн үйлдвэрүүдээс бүрдсэн цогцолбор үйлдвэржилтийн төсөл юм. Үйлдвэр ашиглалтад орсноор гол нэр төрлийн ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээний 30-50 хувийг хангаж 325.7 мянган тонн төмрийн хүдрийн хорголж экспортод гаргахаар төлөвлөж, шинээр 1900 гаруй тогтвортой ажлын байр бий болохоос гадна дагалдах жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих зэрэг Монгол Улсын нийгэм эдийн засагт өндөр ач холбогдолтой үндэсний үйлдвэрлэгч юм.

Гэтэл 2014 онд Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь өөрийн эзэмшлийн Төмөртолгой, Төмөртэй болон Хуст-Уулын төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн төмрийн хүдрийг боловсруулж, төмөрлөг түүхий эдийн хомсдолыг багасгах,

2022000114

үйлдвэрийн хүчин чадлыг өсгөх, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, одоогийн Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөх зорилгоор "Уул уурхай, металлургийн цогцолбор" төслийг хэрэгжүүлэхээр тендер зарлаж гадаад дотоодын нэр хүнд, туршлага бүхий олон компани өрсөлдсөнөөс "Кью Эс Си" ХХК-ыг шалгаруулж Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөх эрх бүхий Эдийн засгийн хөгжлийн яам нь "Кью Эс Си" ХХК-тай концессын гэрээг байгуулсан.

"Кью Эс Си" ХХК нь "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах" төслийн хүрээнд Хандгайт өртөөнөөс Төмөртэйн уурхай хүртэл 33.4 км урт төмөр зам болон ачиж, буулгах терминал барих ажлыг санхүүжүүлэх зориулалтаар 2014 онд Монгол Улсын Хөгжлийн банктэй зээлийн гэрээ байгуулж, 2015 оны арванхоёр дугаар сард гэрээний нэмэлт, өөрчлөлтөөр 71.3 сая ам.долларын зээлийг авсан ба тус зээлийн гэрээгээр 2018 оны арван хоёрдугаар сард зээлээ төлж дуусгах заалттай байсан хэдий ч "Кью Эс Си" ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй учраас Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж зээлдэгч компаниас зээл, зээлийн үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт 200 гаруй тэрбум төгрөгийг гаргуулахаар нэхэмжлэл бичиж шүүхэд хандсан.

Нэхэмжлэлийн дагуу "Кью Эс Си" ХХК-аас үндсэн зээлийн үлдэгдэл, үндсэн хүүгийн үлдэгдэл, нэмэгдүүлсэн хүүгийн үлдэгдлийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, нэхэмжлэл гаргасан үеийн ханшаар буюу нийт 192,572,187,590.244 /нэг зуун ерэн хоёр тэрбум таван зуун далан хоёр сая нэг зуун наян долоон мянга таванзуун ер/ төгрөгийг Хөгжлийн банканд олгуулахыг 2022 оны нэгдүгээр сарын 14-ний өдөр Улсын дээд шүүх шийдвэрлэсэн.

Улсын Их Хурлаас 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр захирамж гарган ажлын хэсэг байгуулан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөгжлийн банкны чанаргүй зээлийн талаар холбогдох байгууллагуудтай хамтран хийсэн шалгалтаар "Кью Эс Си" ХХК-тай концессын гэрээг хууль зөрчиж байгуулсан, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, зээлийн үйл ажиллагааны журмын тодорхой заалтуудыг зөрчсөн болохыг тогтоосоноор "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийг төрд буцаан авах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлсэн.

Түүнчлэн АТГ-аас Засгийн газарт 2022 оны дөрөвдүгээр сарын 7-ны өдөр Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн үйл ажиллагааг өргөтгөн техник технологийн шинэчлэл хийж үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, ТЭЗҮ боловсруулах гэрээг ажлын туршлаггүй байгуулагдаад удаагүй байсан "Кью Эс Си" компанитай байгуулах дүгнэлтийг хөрөнгө оруулагчыг сонгон шалгаруулах ажлын хэсгээс гаргахдаа хууль зөрчиж удирдлагаас өгсөн хууль бус үүргийг биелүүлсэн болох нь тогтоогдсон" гэх мэдэгдэл болон бусад нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн концессын гэрээг цуцалж удирдлагын болон өмчлөлийн эрхийг төрд шилжүүлж авах шийдвэрийг гаргаж, концессын гэрээ байгуулах тухай Засгийн газрын 2015 оны хоёрдугаар сарын 28-ны өдрийн 69 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон.

Ингээд Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг "Кью Эс Си" компаниас хүлээж авахад 664 тэрбум төгрөгийн өртэй, 370 тэрбум төгрөгийн авлагатай байсан бөгөөд 2021 онд 40 тэрбум, 2022 онд 30 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан гэх боловч 122 тэрбум төгрөгийн татварын өр төлбөртэй санхүүгийн хувьд маш их алдагдалтай компанийг хүлээн авсан.

Иймээс "Кью Эс Си" ХХК-тай холбоотой дээрх хууль бус үйл ажиллагаа болон татвар, санхүүгийн маш олон зөрчлүүд, тэдгээрийг арилгах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тодруулах, дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. 2014 онд Монгол Улсын Засгийн газар тендер зарлахад БНСУ-ын "Поско", БНЭУ-ын "Меско стийл", "Ай Си Эм", БНХАУ-ын "БаоГан", "China National Precision Machinery I/E Corporation" гэсэн дэлхийд нэр хүнд бүхий бизнесийн арвин туршлага бүхий 5 корпорациуд өрсөлдөөд Монгол Улсын бүртгэлд бүртгүүлээд хоёрхон жил болсон, үйл ажиллагаа явуулаагүй "Кью Эс Си" компанид ялагдсан байдаг. Дээрх сонгон шалгаруулалт хэрхэн явагдсан талаарх дэлгэрэнгүй тайлан, баримт мэдээллийг гарган ирүүлэх,
2. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр"-ийг төр мэдэлдээ авч Засгийн газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, МХЕГ-аас шалгалт хийж шалгалтаар маш олон зөрчил илэрсэн. Дээрх байгууллагуудын шалгалт дуусаад нэлээдгүй хугацаа өнгөрсөн боловч шалгалтын тайлан үр дүнгийн талаар одоо болтол яагаад албан ёсны мэдээлэл олон нийтэд өгөхгүй байгаа талаар тайлбар мэдээлэл,
3. "Кью Эс Си" ХХК-тай холбоотой маш олон санхүүгийн зөрчлүүд илрээд байгаа. Тухайлбал 2014 онд концессын гэрээ байгуулсаныхаа дараа хуульд байхгүй, концессын гэрээнд тусгагдаагүй "менежментийн үйлчилгээний төлбөр" гэсэн төлбөрийг жил бүр 10,0 сая доллар нийтдээ 120 тэрбум төгрөгийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр"-ээс авсан нь баримтаар нотлогдсон. Засгийн газраас дээрх шалгалтуудын хүрээнд уг асуудлыг шалгасан эсэх талаарх мэдээлэл,
4. "Кью Эс Си" ХХК нь 2014 онд байгуулсан концессын гэрээний 6 дугаар бүлгийн 6 дах хэсгийн 6.33-т "Концесс эзэмшигч нь энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд ногдох албан татвар, төлбөр хураамж болон концессын зүйлийг ашиглах, эзэмших үйл ажиллагаа явуулахтай холбогдон гарсан аливаа зардал, төлбөрийг өөрөө бүрэн хариуцна" гэсэн үүргээ зөрчиж 123 тэрбум төгрөгийн татварын өртэй байна. Энэ асуудлыг шалгаж өрийг төлүүлэх талаар авсан арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээлэл,
5. Концессын гэрээний хугацаанд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, эд хөрөнгө, эрх, газар гэх мэт барьцаалж болох бүхнийг банкуудад барьцаалж, үндсэн зээлийн 10 гэрээ, барьцааны гэрээ нийт 50 гаруй гэрээгээр авсан зээлээс 160 гаруй удаагийн гүйлгээгээр нийт 168.4 тэрбум төгрөг, 69.9 сая ам доллар буюу нийт 230 гаруй тэрбум төгрөгийг "Кью Эс Си" ХХК руу шилжүүлсэн байна.
Өөрөөр хэлбэл Төмөрлөгийн үйлдвэрээр зээл авахуулаад тэр мөнгийг нь өөрсдөө тэр өдөртөө шууд "Кью Эс Си" ХХК-ийн данс руугаа шилжүүлэн авсан. Үүний хүүгийн авлага 74.3 тэрбум төгрөг, 21.9 сая доллар ХХБ-нд төлсөн байна. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагаанд ийм зээл авах шаардлагагүй байхад "Кью Эс Си" ХХК нь зээл авч ХХБ-нд 540 гаруй тэрбум төгрөгийн өрөнд оруулсан. Энэ асуудлыг шалгаж тогтоосон талаарх мэдээлэл,
6. 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр "Кью Эс Си" ХХК, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-тай "Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн

туслалцаа үзүүлэх гэрээ” буюу Менежментийн гэрээ байгуулж Металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх явцад болон Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагаанд Кью Эс Си ХХК-иас Монгол улсын болон олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд нийт 12+1 чиглэлээр 50 ажил үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахаар байгуулж менежментийн төлбөрт 2017-2021 оны 129,883,079,739.50 /нэг зуун хорин есөн тэрбум найман зуун наян гурван сая далан есөн мянга долоон зуун гучин есөн төгрөг тавин мөнгө/ төгрөгийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дансаар 11 удаагийн гүйлгээ хийсэн нь баримтаар нотлогдож байна. Засгийн газраас энэ асуудлыг шалгасан талаарх мэдээлэл,

7. Засгийн газраас “Кью Эс Си” ХХК-ийн эзэмшиж байсан “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” концессын гэрээг цуцлах шийдвэр гарсны дараа “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-т даргаар ТӨБЗГ-ын бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Шинэхүүг түр орлон гүйцэтгэгчээр томилж байсан юм. Өнгөрсөн дөрөвдүгээр сард ТӨБЗГ-ын дэд даргаар ажиллаж байсан А.Ариунболдыг тус компаний гүйцэтгэх захирлаар томилсон. Гэтэл 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэлийн тушаалаар “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийн захирал А.Ариунболдыг чөлөөлж, Г.Дугаржавыг томилжээ. Энэ томилгоо ямар үндэслэлээр хэний заавар чиглэлийн дагуу хийгдсэн талаарх албан ёсны хариуг ирүүлэх, Г.Дугаржав нь концесс эзэмшигчидтэй ашиг сонирхол нэгтэй, шүүхэд нөлөөлөх замаар концессыг сэргээх алсын зорилготой ажил болж байгаа талаар мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр цацагдаж байгаа мэдээллүүд үнэн бодитой эсэхийг шалгасан эсэх, дээрх мэдээллүүдэд албан ёсны тайлбар хариу ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б. БАТТӨМӨР

2022000114